



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

2025 оны 01 дугаар сарын 02

Дугаар 0013

Улаанбаатар хот

Тамга, тэмдгийн хяналтын  
дугаар хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.7.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам"-ын 14-д заасныг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Хүн байгаль трейд ХХК (6207537)-ийн гүйцэтгэх захирал Д.Даваахүүгийн гаргасан хүсэлтэд Манай Хүн байгаль трейд ХХК нь тамга, тэмдгээ хаяж үрэгдүүлсэн тул хяналтын дугаар шинээр олгож өгнө үү." гэсний дагуу мэдээллийн санд бүртгэлийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд Хүн байгаль трейд ХХК-нд 2017 оны 7 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэгч О.Цэлмэг 1117247017 дугаартай хяналтын дугаар олгосон бүртгэл, Монгол Улсын иргэн Д.Даваахүү 100 хувийн хувьцаа эзэмшиж байна. Гүйцэтгэх удирдлагаар Д.Даваахүү бүртгэлтэй байх бөгөөд өнөөдрийн байдлаар тус хуулийн этгээдэд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хоригийн бүртгэл бүртгэгдээгүй байна.

2.Хүн байгаль трейд ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Даваахүүгийн гаргасан хүсэлт, түүнд хавсаргаж өгсөн нотлох баримтыг хянан үзэхэд: Чингэлтэй дүүргийн 3 хороо, 2-р 40,000-т, 19-1 тоот хаягт байршилтай, Хүн байгаль трейд ХХК-ийн тамга, тэмдгийн хяналтын 1117247017 дугаартай тэмдгийг гээгдүүлсэн тухай 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр, түүнд гүйцэтгэх захирал Д.Даваахүүгийн гарын үсэгтэй, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн гүйцэтгэх захирал Д.Даваахүүгийн гарын үсэгтэй хүсэлт, хүчингүйд тооцсон тухай Өдрийн сонины 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн №245(7611) дугаартай зар зэрэг нотлох баримтаар Хүн байгаль трейд ХХК нь тамга, тэмдгийн хяналтын 1117247017 дугаартай тэмдгийг гээсэн болох нь нотлогдож байна.

3.Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Хүн байгаль трейд ХХК-ийг 500 нэгжээр тorgож, энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 250 нэгжээр хөнгөрүүлж, тorgож шийтгэл оногдуулсан тухай

112502352

Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн 824694 дугаартай шийтгэлийн хуудас байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1-т “Хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт “Тамга, тэмдэг устсан, түүнийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцож, хяналтын дугаарыг улсын бүртгэгч ажлын 2 өдрийн дотор дахин олгоно.” гэж заасныг тус тус баримтлан ДҮГНЭХ нь:

- 1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 6207537 регистрийн дугаартай Хүн байгаль трейд ХХК-д олгосон тамга, тэмдгийн хяналтын 1117247017 дугаарыг хүчингүй болгох.
- 2.Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Хүн байгаль трейд ХХК-д мэдэгдэх.
- 3.Байгууллагын цахим сайтад байршуулах арга хэмжээ авах.

Дүгнэлтийн хувийг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлэх.

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

М.МОНХГЭРЭЛ

